

МЭРГЭН ХИЙДИЙН МОНГОЛ УНШЛАГЫН АЯ ДАНГИЙН
ОНЦЛОГИЙГ ШИНЖЛЭХ НЬ

Бао Дархан

Чү Гоо

Түлхүүр үг: *Монголын Бурхан шашин, Монгол уншлага, ая дан, Мэргэн хийд, хэмнэл*

Монгол уншлагын ая нь монгол үсэг бичгээр бичигдсэн бурхан шашны судар номыг монгол хэлээр унших үед бүрэлдэн тогтсон ая дан болно. Монгол уншлагын ая хэдийгээр монгол бурхан шашны дунд тоогоор нэлээд цөөн, харьцангуй бага хэрэглэгдэх боловч хамгаас илүү үндэстний шинж бүхий шашны ая дуу юм. Тэр нь бурхан шашны ном уншлагын ая, нэн цаашлаад бүхий л монгол бурхан шашны соёлын систем дотор хамгийн онцлог бүхий, хамгийн чухал шашны соёлын элемент болно. Монгол хэлний ном номлохуй, жич түүний ая дууны бүрэлдэл хөгжил нь Төвөд бурхан шашны монголжсон явцыг гэрчилж байна. Энэ нь зөвхөн ном номлох хэлбэрийн өнгөн талын хувиралт биш, харин монгол соёлын Төвөд бурхан шашны соёл лугаа амжилттай уялдаж чадах эсэхийг тогтоох гүн далдын ач холбогдолтой юм. Мөн Төвөд бурхан шашны монголжих явцын урьтал нөхцөл болно. Төвөд бурхан шашин монгол оронд анх дэлгэрэх үед зарим эрдэмтэн, лам нар нэгэнт төвөд номыг монголчлох ажлыг хийж байсан бөгөөд урьд хожид цөөн бус монгол бурхан номыг орчуулсан байдаг. Гэтэл монгол ном уншлагын системийн бүрэлдэл жич төгөлдөржилт нь харьцангуйгаар нэлээд оройтсон бөгөөд дэлгэрүүлж, түгээмэлжүүлж чадсангүй. Зөвхөн цөөн хэмжээний монгол сүм хийдэд уламжлан залгамжлагдаж, түүний бадруулбаас зохих үйлдлээ бадруулж чадсангүй. Энэ бол монгол бурхан шашны соёлын хөгжилтийн дундах их хохирол болно.

Монголчууд бурхан шашинд орсны эхний үед чухам ямар хэлээр ном уншиж байсан тухай тодорхой сурвалж бичгийн тэмдэглэл байхгүй. Олонх хүмүүс Төвөд хэлээр уншиж байсан гэж үзэж байсан бол зарим эрдэмтэд Уйгар хэлээр уншиж байсан гэж үздэг (Наранбат, Мөнх, 1997:251). Монгол лам нар чухам ямар хэлээр ном уншиж байсныг хожимын эрдэмтэд заавал шинжлэх ухаанч баримт хэрэглэгдэхүүнээр нотлох хэрэгтэй. Гэвч анх эхэндээ монгол хэлээр уншиж байгаагүй нь ойлгомжтой. Монгол лам нар аль цагаас эхэлж монгол хэлээр ном уншлага хийж байсан тухай мөн тодорхой тэмдэглэл байхгүй. Археологчдын илрүүлснээр (1902-1914 он, одоогийн Шинжаанаас) 14-р зууны эхээр, монгол шашны ном судрыг орчуулахаар барахгүй монгол хэлээр лам ба бурхныг магтан дуулах шүлэг зохиол зохион бүтээж эхэлжээ (Чойж, 2003:235-274). Мөн монгол хэлээр ном номлож эхэлсэн ч магад. 14-р зууны үед монгол лам нар монгол хэлээр ном номлож байсан эсэхийг нотлох сурвалж бичгийн тэмдэглэл бидэнд хараахан олдоогүй байна. 13-14-р зуунд бурхны номыг их хэмжээгээр монгол хэлнээ орчуулж байсан бөгөөд монголоор ном зохиол туурвиж байснаас ажихад энэхүү хугацаанд монголоор ном уншиж байсан магадлал их байна.

Монгол ном уншлага бий болсон оновчтой мөртөө тодорхой цаг хугацаа бол 16-р зууны эхэн үе болно. Монголын дээд лам Нэйж тойн хутагтаас (1557-1653) хамгийн анх монгол ном

уншлагыг зохион дэлгэрүүлсэн юм. Монгол ном уншлага нь Нэйж тойн болон түүний шавь нарын олон жилийн хүчин чармайлтын дүнд бүрэлдэн тогтсон ном номлох систем болно.

Нэйж тойн хутагт 1629 оны үеэр шавь нараа дагуулж Хорчин нутгаар шашин дэлгэрүүлэхээр явж, Түшээт хошууны (одоогийн Хорчин баруун гарын дунд хошуу) Баянхошуу хийдийг байгуулж, “Эцэг богд” лам хэмээн өргөмжлөгдсөн байв. Тэрээр мөн Хөххотын Бага зуу сүмийг засан шинэтгэж, тэнд ном уламжлан, номын ёсыг дэлгэрүүлэв. Түүний нөлөөн дор тус хоёр сүм монгол хэлээр ном номлох уламжлалыг баримталж байв. (Одоо уг хоёр сүмд Төвөд хэлээр ном унших болжээ). Энэ хоёр хийдээс гадна түүхэнд Нэйж тойн хутагтын бүтээсэн монгол уншлагыг хөгжүүлж бадруулсан сүм хийд гэвэл: Өвөр монголын Урадын мэргэн хийд (Хуучны Урадын гүнгийн хийд, Дэвсгийн хийд зэрэг хориод хийд бий), Баарин баруун хошууны Төгс-Бүртгэлт сүм, Ар хорчин хошууны Зарлигаар Хишгийг Шүтэгч Сүм, Жарууд хошууны Гэгээн хийд, Халх Монгол дахь Говь Мэргэн Вангийн хошууны Хоньчин хийд, Түшээ гүн хошууны Билгүүн хийд, Бээжингийн Шар Сүм зэрэг сүм хийдэд бас монгол ном номлох ёслолыг уламжлан байжээ. Эдгээр сүм хийдийн дундаас Урадын Мэргэн хийд л эртнээс одоо хүртэл бүрэн бүтнээр монгол уншлагаа хэвээр нь тасралгүй баримталж, монгол ном номлох систем цогцыг уламжлан хөгжүүлсээр иржээ (Наранбат, 1992:72). Мэргэн хийд нь монгол бурхан шашны хөгжилд асар том хувь нэмрээ оруулсан чухал сүм юм.

Мэргэн хийдийн үе бүрийн хутагт гэгээн болон эрдэмтэн лам нарын өөрийн үндэстнийхээ соёлоо залгамжлан хөгжүүлэх гэсэн хүслээ практикт оруулснаар өнөөдөр бид монгол ном уншлага гэх энэхүү монгол соёлын өв хөрөнгийг ойлгон таних завшаантай болов. Мэргэн хийдийн ном уншлагын ая нь монгол бурхан шашны ном болон уншлагын ая дууны онцлог шинжийг хамтруулснаас монгол ном уншлагын ая дууны төлөөлөх чанар бүхий сонгодог бүтээл болж чадсан байна. Мэргэн хийдийн ном уншлагын систем жич ном уншлагын аяыг байцаан судлахаар дамжиж, монгол хэлний ном уншлагын аяын өнгөрсөн ба өнөөдрийг бүрэн ойлгон мэдэж болно.

Урад гүнгийн хошууны Мэргэн хийд нь XVIII зууны эхэнд байгуулагдав. Түүний монгол хэлний ном уншлага ба ая нь адил бус хөгжлийн явцыг дамжсан байна. Бодитой хэлбэл “Үүдэлтийн шат” болон “Төгөлдөржилтийн шат” гэх хоёр үе шатад хувааж болно. Хоёр шатны хуваарилалтаа уг хийдийн гуравдугаар дүрийн Мэргэн гэгээн Лувсандамбийжалцангаар зааглалын цэг болгон хоёр анги хувааж болно. Лувсандамбийжалцанаас өмнөх “Үүдэлтийн шат”-ны монгол ном уншлагыг “Монгол номын хуучин уншлага” гэж, түүнээс хойших “Төгөлдөржилтийн шат”-ны монгол уншлагыг “Монгол номын шинэ уншлага” гэнэ.

“Монгол номын хуучин уншлага” нь гурван үеийн зүтгэлтнүүдийн хатуужилтай чармайлтыг дамжжээ. Анх үүдэгч нь Өвөр монголын дээд лам Нэйж тойн гэгээн, залгаад түүний ууган шавь, Мэргэн хийдийн нэгдүгээр дүрийн гэгээн Динваа цаашид улам нэг алхам бататган дэлгэрүүлэв. Хожим нь 2-р дүрийн Мэргэн гэгээн Данзанжамц мөн цаашид баримтлан хөгжүүлснээр мэргэн хийдийн нэлээд тогтвортой ном номлох загвар болон бүрэлдэн тогтсон байна. Энэхүү явцад номч Өглүүндалай, Номундалай ба Дамбийжалцан зэрэг эрдэмтэн багш нар хувь нэмрээ оруулжээ. “Монгол номын хуучин уншлага” нь ёслолын хэлбэр, ном номлохын ая дан, үг өгүүлбэрийн таслал гэх зэрэг талд тохиромжгүй газар олон байж, зохих хэмжээгээр цааш үргэлжлэн хөгжихөд саад болсон байна. “Монгол номын хуучин уншлага” нь хэдэн үеийн чармайлтаар, зуу шахам жилийн бүрэлдлийн явцыг дамжиж, Төвөд бурхан шашны уншлагын ном судрыг монголчлох ажлыг үндсэндээ биелүүлж, мөн түүнийг бодитой ном номлох ёслолд хэрэглээд монголоор ном номлох загварыг үндсэндээ бүрэлдүүлжээ. Энэ нь хожмын монгол ном уншлагын хөгжлийн суурийг тавьсан бөгөөд элбэг баян туршлага болсон байна (Мөнх, 1995:113-115). “Монгол номын шинэ уншлага” нь “Монгол номын хуучин уншлага”-ын зохисгүй талыг залруулахын

дагуу аажмаар бүрэлдэн тогтсон юм. Энэ бол “Монгол номын хуучин уншлага”-д хийсэн төгөлдөржүүлэлт болохоос биш, шинээр зохиосон зүйл биш. Энэхүү төгөлдөржүүлэлтийн ажлыг хийсэн чухал хүн бол 3-р дүрийн Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан (1717-1766) юм. Лувсандамбийжалцан нь XVIII зууны монгол бурхан шашин цаашлаад бүхий л монголын түүхэнд ч чухал байр суурь эзэлсэн хүн. Тэрээр бурхан шашинд нэвтэрсэн дээд лам болохоор үл барам монгол, төвөд, хятад, манж, санскрит зэрэг үг хэл, үсэг бичигт нэвтэрсэн их эрдэмтэн билээ. Тэрээр шүлэг найраг зохиож чадахаар үл барам бас ая зохиож дуу бичдэг шүлэгч, хөгжимч хүн байсан юм. Лувсандамбийжалцан насан турш маш олон шүлэг дуулал зохиож, зарим нь одоог хүртэл уламжлагдан ардын дунд шүлэгт дууны хэлбэрээр тархан дэлгэрсээр байна.

Лувсандамбийжалцаны өргөн мэдлэг үлэмж чадвар, түүний дуу хөгжмийн авьяас билиг нь “Монгол номын хуучин уншлага”-ыг засан төгөлдөржүүлэн, “Монгол номын шинэ уншлага”-ыг бүтээхэд чухал үйлдэл үзүүлсэн нь бат ноттой. Түүний чухал гавьяа зүтгэл гэвэл бурхны номын уншлагын монгол ном судрыг шүлгийн хэлбэртэй болгон дүрэмжүүлж, уншлагын айзам цохилгыг жигд тэнцүү болгосон явдал юм. Цаашлаад ном номлохын ая аялгууг дахин шинээр зохиож найруулаад, шашны номын шүлэг болон уншлагын аяыг бүрэн бүтэн уялдуулах нүсэр ажлыг хийжээ. Лувсандамбийжалцаны бүтээсэн шинэ уншлагын арга нь “дуган дүүрэн суусан хэдэн арваас хэдэн зуун тооны үсэг бичиг таних, танихгүй лам хуврагууд эх монгол хэлээр тийм жигд, тэгш яруу сайхан аялгуулан хурж чаддаг” (Мөнх, 1995:467-469)-ийг биелүүлсэнд байна. Түүний “Монгол номын шинэ уншлага”-ыг бүтээх явцад хийсэн хамгийн чухал ажил нь ном уншлагын айзам цохилгыг нэгтгэсэн явдал болох юм. Даруй номын шүлгийн мөрүүдийн айзам цохилгыг тэгшилсэн байна. Лувсандамбийжалцан өөрөө үүнийг бас “Шад тэгшлэх” (Мөнх, 1995:468) гэж нэрийджээ. “Шад”-ыг тохируулан тэгшитгэсэн явдал бол Лувсандамбийжалцаны шинэчилсэн “Монгол номын шинэ уншлага”-ын чухал онцлог болно. Мөн “Монгол номын хуучин уншлага” лугаа хамгийн их ялгаатай тал юм. “Монгол номын шинэ уншлага” дахь “шад”-ын хэв шинжийн бүрэлдэл нь хэдийгээр төвөд ба санскрит хэлний шүлэг дуулалтай зохих хэмжээний холбоотой боловч Монгол үг хэл, үсэг бичгийн онцлогт нийцүүлснээр Төвөд хэлний ном уншлагаас маш их зөрөөтэй юм. “Монгол номын шинэ уншлага”-д гагцхүү шүлгийн хэмнэлийг жигдэлсэн төдий бус бас ном уншлагын аяыг дахин зохиож найруулсан бөгөөд шүлэг болон аяын уялдлыг ч амжилттай зохицуулсан байна. Монгол ном уншлагын олон арвин онцлогийн тухай бид судлахдаа голдуу Өвөр Монголын Мэргэн хийдийн уламжлан хөгжүүлсэн монгол ном уншлагаар жишээ болгон ажилласан юм.

“Усныхын магтаал”-ын бүгд урт нь нийт 11 минут 47 секунд, нийт 47 бадаг шүлэгтэй, бадаг бүр нь дөрвөн мөр шүлгээс бүтэв. Номлохын ая дангийн онцлогийг үндэслэвэл тус магтаалыг гурван хэсэг (АВА-гийн загвар шиг) болгон задалж болно. Хэсэг бүрийн эл бадгийн номлох ая нь үндсэндээ адил болохоор задлалтад зөвхөн хэсэг бүрийн 1-2 бадгийг сонгон жишээ болгов. Гурван хэсгийн хоёрдугаар хэсэг нь төвөд хэллэгийн нууц тарни болохоор тус задлалтад багтаан оруулаагүй. Харин монгол уншлагын ая шүлгийн онцлогоор илэрхий байх 1-р хэсэг, 3-р хэсгээр голлон жишээлэв. “Усныхын магтаал”-ын аяаас мэдэх нь 3-р хэсгийн ая нь 1-р хэсгийн аяаас улиран хөгжиж бүтсэн. Гэвч уншлагын ая болон шүлэг лүгээ хавсаргасан талаар 1-р хэсгээс илэрхий өөр байна.

Ая: 1

Уснихын Магтаал

Уншлага: Лувсансэнгээ
Нот тэмдэглэгээ: Бао Дархан

Ха маг ял гуг са д ын Бэл гэ би лэг нэ г нээ
Эр хин о хин тэн гэр ыг Са ран мэ т өн гө тэй

Ху раа сан ус ни х Би зи яа дур мөр гө мүү
Гурван ни гүүр най ман гар Ма ш гова дур мөр гө мүү

Ая: 2

Уснихын Магтаал

Уншлага: Лувсансэнгээ
Нот тэмдэглэгээ: Бао Дархан

♩=98-102

Тө гөсцог т о хинтэнгэр Гэгээхэн са ран өн гө тэй Гурван нигүүрнаймангар т

А мур лангуй би е тэй Цаглш г үй бэл гэ би лэг на сан шидийг ө гөө ч

Ма ш я л гуг сан э хийн өл зий ху таг о р орш

“Уснихын магтаал”-ын 1-р хэсэг (ая 1) нийт 21 бадаг шүлгээс бүрэлджээ. Бадаг бүрдээ 4 мөр шүлэгтэй. 21 бадаг шүлгийн уншлагын ая нь ч 21 бадаг. Бадаг бүрдээ 4 хөгжмийн өгүүлбэртэй. Үүнээс бид тус магтаалын нэгэн бадаг шүлэгт яг нэгэн бадаг ая тохирч, нэг мөр шүлэгт яг сайхан нэг хөгжмийн өгүүлбэр зохицон тохироод шүлэг болон ая нь тооны талаар харилцан тэнцүү болсныг мэдэж болно. Уншлагын аяын айзмыг үндсэндээ зургаан нэг (нэг айзмын нэгж дөрвөн хувьт дууны цаг хэмжээтэй тэнцүү) болгон тэгшээр хуваажээ. Энэхүү айзмын хэмнэлтэй зохицуулахын төлөө ном номлохын явц дахь шүлгийн хэмнэл ч ихээр хувирснаас нэг зүйлийн шинэ намбаа бүхий шүлгийн хэмнэл (бадаг бүрийн хэм хэмжээ) буй болсон. Энэхүү шинэ хэмнэл уламжлалт монгол шүлгийн хэмнэл, хэм хэмжээг тэрсэлснээс болж лут их зөрөөтэй болсон. Бодитойгоор хэлбэл:

“Уснихын магтаал”

Эхний хоёр бадаг	Уламжлалт уншлага дахь хэмнэл
Хамаг ялгугсадын	— v —
Бэлгэ билэг нэгнээ	— v —
Хураасан усних,	— v —
Бизьяа дур мөргөмүй	— v —
Эрхин охин тэнгэр,	— v —
Саран мэт өнгөтэй	— v —
Гурван нигүүр найман гар	— v —
Маш гова дур мөргөмүй	— v —

Олны мэдээжээр, ерийн хэллэг болон уншлагад монгол хэлийг үгчилж ярьдаг. Даруй өгүүлбэрийн хэмнэл нь холбон яригддаг нэг үг буюу хэдэн үгээр зогсолтын нэгж болгодог. Харин үсгийн үе буюу авиагаар зогсолт болгох бус. Эс тийм бол өгүүлбэрийн утга ойлгомжгүй болдог. Жишээ нь: “Хамаг ялгугсадын” гэх холбоо үг нь хоёр бодит үг болон нэг дагавраас бүтжээ. Уншихад, дунд нь зөвхөн нэг л удаа зогсоно. Даруй “Хамаг/ялгугсадын” болно. Гэтэл монгол бурхан шашны ном номлоход энэхүү уламжлалт хэлний дүрэм өөрийн үйлдлээ бүрмөсөн алдаж, маш олон удаа зогсох үзэгдэл гардаг, энэ нь даруй номлох аясын айзмын жам хуулиас шалтгаалжээ. Монгол ном номлоход номын аяын айзамтай зохилдуулахын төлөө, бурхан номын үг өгүүлбэрийг шинээр тохируулж, бүрмөсөн өөр шүлгийн хэмнэл буй болгодог. Бодитой хэлбэл:

Тэргүүн хоёр бадаг	Ном номлох дахь хэмнэл
Хамаг/ яла/ гуг/ са/ д/ ын/	— v — v — v — v — v —
Бэлгэ/ би/лэг/ нэ/гэ/нэ/	— v — v — v — v — v —
Хури/яаг/сан/ ус/ни/ха/	— v — v — v — v — v —
Бизи/яа/ дур/ мөр/гө/мүй /	— v — v — v — v — v —
Эрхин/ о/хин/ тэ/гэ/ри/	— v — v — v — v — v —
Саран/ мэ/тү/ өн/гө/тэй/	— v — v — v — v — v —
Гурван/ ни/гүүр/ най/ман/ гар/	— v — v — v — v — v —
Маш/ гова/ дур/ мөр/гө/мүй/	— v — v — v — v — v —

Үүнээс үзэхэд ном номлох үг өгүүлбэрийн зогсолт нь энгийн уншлагын зогсолтоос ихээхэн ондоо болжээ. Даруй уншлагын хэмнэл нь туйлын жигд тэгшхэн болдог. Дээрх задлалтаас мэдэх нь ном уншлагын зогсолтын нэгж (хэмнэл)-д ганцхан эгшиг авиа бүхий (үе) байдаг, хэдийгээр бодит бичлэгийн дунд зарим зогсолтын нэгжид хоёр эгшиг авиан үе байдаг боловч түүний доторх нэгэн эгшиг авиа нь дуудагдахгүй байдаг. Шүлгийн иймэрхүү зогсолтын дүрмийг номын аятай харьцуулбал нэгэн сонин онцлог тодордог. Даруй шүлгийн нэг зогсолтын нэгж нь аяын нэг цохилго болно. Өөрөөр хэлбэл, аяын нэг цохилго нь шүлгийн нэг эгшиг авиатай харгалзаж буй. Бодитой хэрэглэлийн үүднээс үзвэл иймэрхүү зогсолтын жам хууль ба үг аяын харилцан харгалзах дүрэм нь хүмүүст амар ойлгогддог мөртөө сүм хийд дэх мянга түмэн лам нарын жигд тэгшхэн номлоход туйлын амар болдог.

“Уснихын магтаал”-ын гуравдугаар хэсэг нь нийт долоон бадаг шүлэг болон долоон бадаг ая буй. Түүний дотор 1-р бадаг нь шилжилтийн бадгаас болж жаахан өөр байдаг. Бусад зургаан бадаг нь бүрмөсөн адилхан байдаг. Нэгдүгээр хэсгийн хөгжмийн өгүүлбэртэй адилгүй газар гэвэл, 3-р хэсэг дэх нэг бадаг ая нь хоёр хөгжмийн өгүүлбэрээс бүрэлдэж, нэг хөгжмийн

өгүүлбэр хоёр мөр шүлгийн үгийг багтаана. Иймээс аяын нэг бадаг нь шүлгийн нэг бадгаас урт болов. Хэдийгээр ийм боловч ном номлох үед үг аяын зохицох ёсон хувираагүй, аясын айзам цохилго нь үндсэндээ тэгшээр хуваагдсан найман хэмнэлийн нэгж байдаг. Үүн лүгээ тохиролцсон шүлгийн хэмнэл доорх мэт:

Уламжлалт уншлага дахь хэмнэл	Хэмнэл бүр дэх эгшгийн тоо
Төгс цогт охин тэнгэр — v —	[4+4]
Гэгээн саран өнгөтэй. — v —	[3+2]
Гурван нигүүр найман гарт — v —	[2+3]
Амарлингуй биетэй. — v —	[3+2]
Ном номлох дах хэмнэл	Хэмнэл бүр дэх эгшгийн тоо
Төгс/цогт/охин/тэнгэр/Гэгээн/саран/өнгө/тэй/	[1]
Гурван/нигүүр/ найман/ гарт/Амар/лингуй/ бие/тэй/	[1]

Нэгдүгээр хэсэг лүгээ харьцуулвал зөвхөн хэмнэлийн нэгжийн тоо нь нэмэгдсэнээс биш бусад жам хууль нь бүгд адил байдаг. Даруй нэг хэмнэлийн нэгжид нэгэн эгшиг авиатай үе хавсруулан тохируулжээ.

“Манжширийн магтаал”

“Манжширийн магтаал” нийт 12 бадаг шүлэг, ном уншлагад ойролцоогоор 5 минут 28 секундын цаг хэрэглэнэ. Магтаалын 1-2-р бадаг болон эцсийн бадгийг доорх мэтээр сийрүүлбэ:

Ялгуусан ганц эцэг

Залуусын дүр барьсан
Бэлгэ билэг таван үснирт
Манжшир тан дур мөргөмүй.

Алтан сүмбэр ууланд наран
Гэрэл тусч бүхэн адил
Гэгээхэн биеийг үзвээс гова
Манжшир тан дур мөргөмүй.

...

Таны билэг наран гэрлээр
Миний мунхаг ойг гийгүүлэн
Зарлиг шастир голыг онохуйн
Оюун билгийг өгөн соёрх¹.

Ном уншлага дахь шүлгийн хэмнэлийн хэлбэрийг шинжилвэл доорх мэт:

Ном номлох дахь хэмнэл	Хэмнэл бүр дэх эгшгийн тоо
Ял/гуусан ганц/ эцэг/г/ — v — v — v — v —	2+2+1
Зал/уусын/ дүр/ барь/сан/ — v — v — v — v —	2+2+1
Бэлгэ/ билэг/ таван/ үснир/т / — v — v — v — v —	2+2+1
Манж/шир/ тан дур/ мөргө/мүй/ — v — v — v — v —	2+2+1

¹ Галлуу С., Жарантай Г. “Мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны бум зарлиг оршвой”. Үндэстний хэвлэлийн хороо, 1986, 399-402-р тал.

Алтан/ сүмбэр/ уулан/д/ наран	— v — v — v — v —	2+2+1
Гэрэл/ тусч/ бүхэн/ адил/	— v — v — v — v —	2+2+1
Гэгээхэн/ биеийг/ үзвээс/ гова/	— v — v — v — v —	2+2+1
Манж/шир/ тан дур/ мөргө/мүй/	— v — v — v — v —	2+2+1
	
Таны/ билэг/ наран/ гэрл/ээр	— v — v — v — v —	2+2+1
Миний/ мунхаг/ ойг/ гийгүү/лэн	— v — v — v — v —	2+2+1
Зарлиг/ шастир/ голыг/ оно/хуй/н	— v — v — v — v —	2+2+1
Оюун/ билгийг/ өгөн/ соёрх/	— v — v — v — v —	2+2+1

Манжширийн Магтаал

Уншлага: Лувсансэнгээ
Нот гэмдэглэгээ: Бао Дархан

$\text{♩}=78$

Ял гуг сан ган ц э цэ г За луу с ын дү р ыг ба рь сан

$\text{♩}=82$

Бэлгэ би лэгта ван үс нирг Манж ширитан дур мөргө мүү Алтан сүм бэруу лан д наран

Гэ рэл дус ч бү хэн адил ы Гэ гээхэн би еийг ү з вээ с говаа

Ман ж ши ри тан дур мө р гө мүү най ман тав хй хү г т а яас ыг

Манжширийн Магтаал

Дээрх хэсгээс залгана хамаг сүүлийн хэсэг

Ман ж ши ри тан дур мө р гө мүү Тан ы би лэг на ран гэ рэл ээр

Ми ний мун хаг ой г гий гүү лэн Зар лиг шас тир голы г о нохуй н

О юун билг ийг өг өн со ёр х

Энэхүү задлалтаас тус магтаал дээрх хоёр магтаалаас өөр байхыг мэдэж болно. Даруй аяын хэмнэл нь ондоо зүйлийн нийлэлтээр илэрч, хэмнэлийн нэгж бүрд эгшиг авиа нэмэгдэн орсон бий. Гурван магтаалаас тус номын уншлагын хурд туйлын удаан. Номлолын хурд удаан болсноос хэмнэлийн нэгж нь задарч, хагас хэмнэлийн нэгж илэрчээ. (Жишээн дэх богино хөндлөн зураас хагас хэмнэлийг илтгэж, урт хөндлөн зураас нь бүхэл хэмнэлийг илтгэнэ). Шүлгийн хэмнэл бүр дэх эгшиг авиа нь айзмын хэмнэлд хуваарилагдсан нь туйлын эмх журамтай байдаг. Даруй бүтэц хэмнэлийн нэгжид хоёр эгшиг авиаг багтааж, хагас хэмнэлийн нэгжид нэг л эгшиг авиа тохирчээ.

Монгол ном уншлагын ая болон шүлгийн харьцаа холбоог тодруулахад дээрх гурван магтаал туйлын ач тустай юм. Бодитой задлалтаас мэдэх нь, монгол ном уншлагын аяын айзам хэмнэл нь жигд тэгшхэн дараалалтай байж, нэг зүйлийн айзам хэмнэл нь ахин дахин давтагдан, олон лам нарын зэргээр жигд уншихад дөхөм мөртөө шүлгийг цээжлэхэд ихээхэн амар байдаг. Аяын айзам хэмнэлээс болж номын үг өгүүлбэрт ч зохих хэмжээний тохируулалт хийж, онцгойлон уншлагын шүлгийн хэмнэл уламжлалт хэлбэрийг тэрслэн шинэ маягийн хэмнэлийг бүрэлдүүлжээ. Ном номлолын явцад аяын хэмнэл болон шүлгийн хэмнэл харилцан органикаар тохиролцохыг онц чухалчилж, айзам хэмнэлийн нэгж бүрд эгшиг авианы жигд тохирохыг ихээхэн анхаардаг. Шүлгийн нэг хэмнэлийн нэгж нь аяын нэгэн хэмнэлийн нэгж болж, нэг хэмнэлийн нэгжид нэгээс хоёр эгшиг авиа (олонхдоо ганц эгшиг авиа) орсон байдаг. Монгол ном уншлага эдгээр талаараа уламжлалт шүлэг дуулаас ихээхэн өөр болов.

Дээрх гурван магтаалын аяын задлалтаар дамжаад монгол уншлагын аяын дуу хөгжмийн онцлогийг доорх мэтээр хураангуйлж болно.

Нэг. Айзам цохилго эмх цэгцтэй, шүлгийн хэмнэл тэгш илэрхий, хөгжмийн өгүүлбэрийн давтамж тогтвортой. “Шад тэгшлэх” нь Лувсандамбийжалцангаас бурхан шашны “Монгол номын хуучин уншлага”-д хийсэн өөрчлөлтийн хамгаас чухал арга хэмжээ болсноос, бид анхаарлаа үүн дээр ирүүлэн хандуулан, бодитой задлалтаар дамжуулан түүний онцлогийн тухай нэлээд тодорхой дүгнэлтэд хүрэв. Монгол ном уншлагын аяын айзам цохилго нь тун эмх цэгцтэй, нэг зүйлийн айзмын загвар эхнээс дуусан дуустал уншлагын дунд давтагдаж, энэ нь цээжлэхэд амар, хамтаар уншихад дөхөм байдаг. Айзмын хэмнэлтэй зохилдуулахын төлөө, бурхны номын шүлгийн хэмнэлд зохих хэмжээний зохицуулалт хийв. Онцгойлон уншлагын дундах хэмнэлийн талд монгол шүлгийн өргөлтийн уламжлалт хэлбэрийг үл баримтлан шинэ загварыг бүрэлдүүлэв. Уншлагын аяын айзам хэмнэл лүгээ авцалдсан шүлгийн өгүүлбэрийн хэмнэл нь хэмнэлийн нэгж бүрд илэрсэн эгшиг авианы тоог чухалчилдаг бөгөөд хэмнэлийн нэгж болон айзмын нэгжийн зохицолдлыг онцгой чухалчилдаг. Нэг шүлгийн хэмнэлийн нэгж бол нэг айзмын хэмнэлийн нэгж болно (онц зарим нь хагас хэмнэлийн нэгж болно). Нэг хэмнэлийн нэгжид нэгээс хоёр эгшиг авиаг багтаана (олонх тохиолдолд ганц эгшиг авиатай байдаг). Уламжлалт монгол шүлгийн хэмнэлтэй ихээхэн адилгүй, энэхүү шинэ хэмнэлийн загварын гол үндэс сурвалж нь энэтхэг төвөдийн үндэстний шүлэг дууллын хэмнэлийн онцлог Лувсандамбийжалцанд өгсөн нөлөө болно. Зарим утга агуулгаас нь авч үзвэл түүний зохиосон энэхүү шинэ маягийн Монголоор ном номлох арга нь үнэнхүү энэтхэг, төвөдийн шүлэгт дууллын хэмнэлийн загварыг “зээлдэн хэрэглэсэн” гэж хэлж болмоор шиг, гэвч түүний энэхүү “зээлдэн хэрэглэсэн” дотор их хэмжээний шинэ нээлт ба үүдэлтийн элементийг агуулж байдаг. “Монгол номын хуучин уншлага” нь монгол ном номлох аргын гол арга болсны хувьд зуугаад жил уламжлагдаж, Монголын соёлд гүн гүнзгий ач холбогдолтой байлаа. Гэтэл түүний үг аяын зохицлын талын дутагдал нь дуган дүүрэн лам нарын эрхбиш хамтаар номлох чанга шаардлагатай зохицохгүй мөртөө хурал номын хэвээр явагдахыг нөлөөлдөг.

Мөн түүний тус биеийн цаашид хөгжихийн харш саад болжээ. Тухайн үеийн лам нар энэхүү дутагдлыг өөрчилж гэж бодохгүй байсан уу? Иймэрхүү бодит үзэгдлийн бүрэлдэл

ба оршин байгаа нь наад зах нь ийм нэгэн асуудлыг харуулж байна. Энэтхэг, төвөдийн шүлэг дууллын хэмнэл нь монгол үг хэл лүгээ зохицохгүй. Учир нь уг гурван хэл нь зөрөө ихтэй, адил бус язгуурын хэл болно. Харин Лувсандамбийжалцанаар түүний “Монгол номын шинэ уншлага”-даа энэ хоёр зүйлийг амжилттайгаар уялдуулж нэгэн цогц болгон, монгол шүлгийн хэмнэлийн шинэ загварыг зохиож чадсан нь түүний мэргэн ухаан гэгээн билгийг тодорхой харуулж байна. Иймэрхүү үүдэлтийг биелүүлж чадсан нь түүний дуу хөгжмийн авьяас билиг ба мэдлэг чадвар лугаа шууд харьцаатай байгаа хэмээн бид үзэж байна. Лувсандамбийжалцан монгол ардын дууг гүнзгий ойлгохоор үл барам дуу зохиож чаддаг. Дуу зохиохын явцад үг аяыг хэрхэн уялдуулах асуудал аяндаа холбогдоно. Үүний тус бие нь даруй дуу хөгжмийн ая айзам болон дууны үгийн хэмнэлийг хэрхэн уялдуулах асуудал болно. Бидний үзэхээр Лувсандамбийжалцаны үүдэлт нь даруй: ном уншлагын ая айзам хийгээд “шад тэгшилсэн”-ий дараах монгол судрын шүлгийн хоорондох төгс уялдлыг биелүүлсэн явдал болно. Үнэн хэрэгтээ монгол ардын дууны үг аяын уялдлын дотоод жам хуулиас тун их сэнхрүүлэл олсон нь баттай байна.

Хоёр. Эгшиглээсийн хувиралт бага, хөгжмийн хэв бүтэц дан цулгуй. Судлалд хэрэглэсэн гурван магтаалын “Уснихийн магтаал”-ын дундах хэсгийн (хүүрнэлийн хэсэг) дараах аялгуу нь жаахан хувиралттай болсныг гаргавал бусад хоёр бурхны магтаал нь бүр ганц ая олонтоо давтагдан дуулагдаж, үлгэрт дууны хэлбэр шиг байдаг. Иймэрхүү үлгэрт дууны хэлбэрийн ном уншлагын ая нь хэчнээн урт бурхны номыг ч гэсэн богинохон дөхөм аяын хэмжээнд хязгаарлаж, хувиралт арвин уншлагын ая лугаа адилтгавал тэр нь амархан уншиж, хялбархан цээжлэх давуу талтай. Бурхны магтаал нь эгшиглээсийн хувиралт цөөнөөр барахгүй аяны бүтэц нь ч тун хялбархан байж, бүр л нэг л хэсэгт аяын хэв болно. Аяын нэг хөгжмийн хэсэг нь ердөө хоёроос дөрвөн хөгжмийн өгүүлбэрээс бүрэлдэж, хөгжмийн өгүүлбэрийг бүтээсэн дууны хэлбэр нь ч дан цулгуй байж, үндсэндээ найман хувьт дууны нийлэлтээр голлоно. Арван зургаан хувьт дуун нь хааяа илэрдэг байна. Ном уншлагын аяын эгшиглээс, хөгжмийн бүтэц, дууны хэлбэр зэрэг талаар бүр л төрөл зүйлээр цөөн байгаа дөхөмчилсөн байдал нь Лувсандамбийжалцаны уншлагын ая зохиож тохируулахын явцад баримталсан нэгэн үзэл санааг илэрхийлж буй. Даруй уншлагын ая нь ном хурлын ёслолд үйлчилдэг. Дуган дүүрэн лам нарын нэгэн дуун мэт хамтаар бурхны номыг номлож дуулахыг батлах хэрэгтэй.

Гурав. Уншлагын ая нь таван дуут аялгууны хэвээр голлож, дуун хэвчээ өргөн, дуун ялгацын үсрэлт нэлээд их, эгшигт чанараар чанга байна.

Монгол ном уншлагын ая нь үндсэндээ таван дуут аялгуун хэв болон монгол үндэстний уламжлалт ардын дуу хөгжмийн хэвшсэн аялгуун хэв, таван дуут аялгууны хэв мөн. Даруй С (до), D (ре), E (ми), G (соль), A (ля)-г зааж буй. Хөгжмийн дууны нийлэлтийн хэлбэр нь төвөд хэлний ном уншлагын ая лугаа харьцуулбал нэлээд баялаг. Төвөд уншлагын гиншихээр голлосон онцлогоос ихээхэн ялгаатай. Уншлагын аяын эгшигт чанарын илүү дутуу байгаа эсэх нь дууны хэвчээ, дууны ялгац, дууны тоотой шууд холбоотой байгааг дээр бүлэгт нэгэнт өгүүлсэн байна. “Уснихын магтаал”, “Богд Зонховын магтаал”, “Манжширийн магтаал” гурван аяаас үзвэл, монгол хэлний ном уншлагын аяын дуун ялгацын хамгийн өргөн нь бага арав, хамгийн явцуу нь цэвэр тавц, энэ нь ерөнхий дуун хэвчээ цэвэр наймц ч хүрэхгүй төвөд хэлний ном уншлагын аяаас хол өргөн байх нь илэрхийлж байна.

Abstract

Mongolian chanting music refers to the music formed when the Mongolian Buddhist scriptures are recited in Mongolian language. Although it is less in number and less in scope, it has the most national characteristics. It is a very important religious and cultural point in the Mongolian Buddhist recitation music and even in the whole Mongolian Buddhist culture system, and its

formation and development directly influenced the Tibetan Buddhism process, it is of far-reaching significance to the development of Mongolian Buddhism. By analyzing the rhythm, rhythm, melodic features and structural features of Mongolian chanting music, this paper aims to explain the style features of Mongolian Buddhist chanting music.

Номзүй

Наранбат Ү., Мөнх Б. 1997. *Мэргэн гэгээн судлалын өгүүллүүд*. Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо.

Чойж. 2003. *Монголын бурхан шашины түүх” (Юан улсын үе)*. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.

Наранбат Ү. 1997. *Монголын буддийн соёл*. Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо.

Мөнх Б. 1995. *Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан*. Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо.

Галлуу С., Жарантай Г. 1986. *Мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны бум зарлиг оривой*. Үндэстний хэвлэлийн хороо.